

“Талх-Чихэр”ХК-ийн Аудитын Хорооны 2014 оны ажлын тайлан

Тус компанийн Аудитын Хороо нь Компанийн тухай хууль болон Аудитын Хорооны ажиллах журмыг баримтлан дарга, гишүүд гэсэн 3 хүний бүрэлдхүүнтэй ажиллаж байна.

Аудитын Хороо нь тус компанийн 2014 оны санхүүгийн ажиллагааны тайлангийн үзүүлэлтүүдэд судалгаа хийж урьд оны мөн үетэй харьцуулан үзэхэд:

Компани байгуулагдаад 31 дэх жилдээ ажиллаж байгаа бөгөөд 2005 оноос хойш тогтмол эдийн засгийн өсөлт дээшилж , эдийн засаг , санхүүгийн үндсэн гол үзүүлэлтүүд өсөж иржээ.

Тус компанийн эдийн засаг , санхүүгийн үзүүлэлт тогтмол өсөж ,ашигтай ажиллаж ирсэний үр дүнд манай компанийн хувьцааны үнэ тогтвортой өсөж 18,0-19,0 төгрөгийн ханштай байна.

Анхны төрийн өмчийн 30%ын оролцоотой байх үеэс тус компанийн ашигт ажиллагаа өсөж, үйлдвэрлэлт борлуулалт жил бүр өсөж,ирсэн байна.

Тус компани хот хөдөөгийн , гадаад дотоодын 4000 гаруй хувьцаа эзэмшигчдэд 2005 оноос хойш давхардсан тоогоор 640020 хувьцаа эзэмшигчдэд 67808090 төгрөгийн ногдол ашгийг өөрийн компанийн санхүүгээр хувиарлаад байна. Зөвхөн 2013 онд 130 гарй хүнд 4895622 төгрөгийг бэлнээр олгожээ.

2014 оны санхүүгийн тайлангийн эдийн засгийн өсөлтийг 2013 онтой харьцуулан үзэхэд:

- 2014 онд 33382,8 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оноос 8450,0 сая төгрөгөөр буюу 33,8 хувиар өссөн байна.
- Борлуулсан бүтээгдэхүүний өртөг 7001,9сая төгрөг буюу урьд оноос 40,1 хувиар өссөн нь үйл ажиллагааны зардал , импортоор авч байгаа материалын болон валютын ханшийн өсөлт , бензин шатахууны өсөлттэй холбоотой өсөлт юм
- Үйл ажиллагааны зардал 1093,5 сая төгрөг болж өссөн нь бүтээгдэхүүний борлуулалт буцалт , хорогдлоос гарсан зардал юм. Энэхүү зардлыг цаашд багасгах , өөрөөр хэлбэл бүтээгдэхүүний чанар , хэрэглэгчийн хэрэгцээ, чанарын удирдлагын хяналтаар сайжруулах шаардлагатай байна
- 2014 онд борлуулалт урьд оноос өссөн байхад түүнд ноогдох зардал 40,1 хувиар өссөн нь тэр хэмжээгээр ашиг буурчээ.
- 2014 онд улсад орлогын татвараар 291,4 сая төгрөг төлсөн нь урьд оноос 31,8 са төгрөг илүү төлж 12,2 хувиар өссөн байна.
- Тус компанийн өөрт 2334,6 сая төгрөг болж урьд оноос 104,7 сая төгрөг буюу 4,6 % болж өссөн байна . Энэхүү үзүүлэлт нь үйлдвэрийн техник , технологийг өргөжүүлэх , бүтээгдэхүүний чанарыг хэрэглэгчдийн эрх ашиг , хэрэгцээнд зориулж өсгөхөд чухал эх үүсвэр юм.

- Эргэлтийн хөрөнгө урьд оноос 1056,0 сая төгрөг буюу 13 хувиар өссөн нь үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээний өсөлт мөн импортоор авч байгаа материал, түүхий эд, сав баглааны валютын өсөлттэй холбоотой үнийн өсөлт юм.
- Хөдлөшгүй хөрөнгө буюу үндсэн хөрөнгө урьд оноос 5851,9 сая төгрөгөөр буюу 28 хувиар өссөн нь үйлдвэрийн байрны өргөтгөл, нарийн боовны шинэ шугам зэргийг шинээр шинэчлэж, тоноглож ашиглалтанд оруулсантай холбоотой. Мөн зарим өргөтгөл шинэчлэлийн ажил үргэлжлэн хийгдэж дуусаагүй байгаа ажилд гарсан санхүүгийн тайлангийн өглөгөөр 6291,0 сая төгрөг, мөн урьдчилж гарсан зардал 3539,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлаар тодорхойлогдож байна.
- 2014 оны санхүүгийн тайлангаар дансны авлага 1,636,5 сая төгрөг өглөг 11078,1 сая төгрөг, авлагаас давсан өглөг 9441,6 сая төгрөг байна. Энэхүү харьцаа нь үйлдвэрийг өргөтгөж, техник технологийг өргөтгөсөн хөрөнгө оруулалтын зардал өссөнөөр тайлбарлагдаж байна. Цаашид хөрөнгө оруулалтын зардлын төлөвлөлтийг урьдчилан төлөвлөж, оновчтой санхүүгийн эх үзүсвэрийг тооцож ажиллах шаардлагатай байна.
- 2014 онд нийт үйлдвэрлэлт 34.098,5 сая төгрөг үүнээс цэвэр борлуулатын орлого 33.382,8 сая төгрөг болж цаад гарч байгаа зөрүү нь 715,7 сая төгрөг нь борлуулатын буцаалт, хорогдлоор тодорхойлогдож байна. Өөрөөр хэлвэл борлуулалтын буцаалт, хорогдол нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 2,0% болж байна. Энэхүү борлуулалтын хорогдол, буцаалт нь 2% боловч 715,7 сая төгрөг нь тийм ч бага тоо биш юм. Энэ борлуулалтын буцаалт, хорогдол нь :
 1. Үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний нэр төрлийг хэрэглэгчийн хэрэгцээ, тэдний байршил, хэрэглэгчдийн худалдан авах чадвар, тэдний сонгол зэргийг сайн судалж менежментийн судалгааг нарийвчлан хийж ажиллах
 2. Үйлдвэрлэл технологийн горим, бүтээгдэхүүний чанар, бүтээгдэхүүний сав баглааны савлалт, түүнд тавих чанарын хяналтыг сайжруулах ялангуяа буцаалт ямар бүтээгдэхүүн дээр, ямар цаг хугацаанд хэрэглэгчийн ямар байршилд их гарч байгааг бүтээгдэхүүний нэр төрлөөр борлуулалтын менежер бүрээр гаргаж, буцаалт гаргадаггүй борлуулалтын менежерүүдийг ажлын үр дүнтэйн уялдуулж урамшил олгож байх, буцаалт их гаргасан борлуулалтын менежерүүдийг эрхэлсэн ажилтай нь уялдуулж тодорхой хэмжээний цалингийн торгуул оногдуулах
 3. Бүтээгдэхүүний үйлдэрлэлт, технологийн болон бүтээгдэхүүний савлагааны ажлын чанарын байдалд хяналтын чанар шалгагчийг бэлэн бүтээгдэхүүний эцсийн дамжлагад шинээр орон тоо гаргаж ажиллуулахаар шинээр журам боловсруулж ажилласан нь шинэ онд борлуулалтын буцаалт багасаж, илүү үр дүнд хүрэх боломж бүрдэх юм.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Аудитын Хороо тайлант оны санхүүгийн үйл ажиллагааны тайлангийн эдийн засгийн үзүүлэлтэд урьд онтой харьцуулан судалгаа хийж, дүгнэлт гаргаж, Хувьцаа Эзэмшигчдийн Хуралд танилцуулж байна.

Аудитын Хороо нь 7 хонгийн Пүрэв гаригт “1997, 2006, 2007, 2008, 2009, 2010, 2011, 2012, 2013” онуудын ноогдол ашгийг компани дээрээ олгож байна. Эдгээр онуудын ноогдол ашгийн олголтын байдлыг дээр дурьдсан билээ. Ноогдол ашгийн олголтыг он бүрээр нь Үнэт Цаасны Төлбөр Тооцоо Төвлөрсөн Хадгаламжийн Төвөөс тодорхойлж гаргасан тухайн онуудын тархалтын судалгаанд авагдсан хувьцаа эзэмшигч бүрийн овог, нэр, регистрийн дугаар, харьяалагдаж байгаа брокер диллерийн компани олгосон сар өдрөөр нь тэмдэглэл хөтлөж олгож байна.

2014 онд ” урьд онуудын амжилтаа улам бататгаж , үйлвэрлэлт борлуулалтын болон эдийн засаг санхүүгийн чадавхи ,ашигт ажиллагааны түвшин дээшилж ажилласныг “ цохон тэмдэглэж “ хангалттай ажилласан ” болохыг хувьцаа эзэмшигч та бүхэнд сонордуулж байна .

“ ТАЛХ-ЧИХЭР ” ХК-ИЙН 2014 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

д/д	үзүүлэлтүүд	2013 он	2014 он	дүн	хувь
1.	Үйл ажиллагааны орлого	24.931,9	33.382,8	8450,0	+33,8%
2.	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	17.428,3	24.430,1	7001,8	40,1%
3.	Үйл ажиллагааны зардал	4.945,0	6.038,5	1093,5	0,3%
4.	Үндсэн бус үйл ажиллагааны				
	/ валютын ханшийн зөрүү	69,0	51,1	-17,9	-3,6%
5.	Татвар төлөхийн өмнөх ашиг	2.489,6	2626,0	134,9	5,4%
6.	Татварын зардал	259,6	291,4	31,8	12,2%
7.	Үлдэх ашиг	2229,9	2334,6	104,7	4,6%
8.	Эргэлтийн хөрөнгө	8019,9	9.076,1	1056,0	13,0%
	/үүнээс түргэн эргэх хөрөнгө/	3438,1	3202,9	-235,2	-1,07%
9.	Үндсэн хөрөнгө	20.728,1	26580,0	5.851,9	28,0%
10.	Бараа материал, бэлэн бүтээгдэхүүн	3177,4	3539,5	369,1	11,0%
11.	Дансны авлага	1481,9	3539,5	2057,6	238,0%
12.	Дансны өглөг	7540,6	13831,	6629,0	183%
13.	Ашигт ажиллагааны түвшин	7,0	7,3	+0,3	+4%